

Католик шашны онцлог

Дунд шавь **Ц.Пүрэвсүрэн**, доктор (PhD)

МУИС, Баруун бүсийн их сургууль.

Хураангуй: *Христийн шашин нь үндсэн гурван урсгал чиглэлд хуваагдан хөгжиж ирсэний нэг томоохон нь Католик шашин юм. Католик шашны тэргүүн нь Ромын их хамба Пап лам юм. Пап нь хамбуудын (кардиналуудын) зөвлөлийн тусгай хуралдаанаас насан турш сонгогддог; түүнчлэн Пап нь Ватикан (мон. Гэгээн Ширээт улс) хот улсын тэргүүний албыг нэгэн зэрэг хашидаг. Пап лам нь дэлхий даяар орших бүх католик сүм хийд, байгууллагуудыг нэгтгэн удирдаж байна. Католик шашны тэргүүний сонголт нь маш эртний түүхтэй бөгөөд нууц санал хураалтаар шийдэгддэг. Одоо дэлхийн 69 орны 203 кардинал байна. Тэд улаан нөмрөгөөрөө католик шашны бусад санваартнуудаас ялгардаг.*

Түлхүүр үг: христийн шашин, католик шашин, үнэн алдартны шашин, протестант шашин, Ромын Пап, шашны зан үйл, мөргөл, ёслол, Есүс, Тэнгэрбурхан.

Орчин үеийн католик шашин Европ, Америк Африк, Ази, дэлхий даяар 1,2 тэрбум гаруй итгэгчидтэй. Католик шашинтнууд шашин, сүм хийдийн үйл хэргийг нийгмийн хамгаалал, боловсрол, олон улсын байгууллага нийгэмлэг, төрөл бүрийн төсөл хөтөлбөрөөр дамжуулан дэлхийн улс орнуудад түгээн дэлгэрүүлж байсан, байгаа, цаашид ч улам улам боловсронгуй хэлбэрээр төгөлдөржиж хэрэгжих нь дамжиггүй. Учир нь, Ромын Пап манай улсад айлчлахдаа хэлсэн үгэндээ “...католик шашинтнуудын үйл ажиллагаа шашны зан үйлээс гадна боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, судалгаа, соёлын дэвшил зэрэг хүний цогц хөгжлийн төлөөх олон санал санаачилгад чиглэсэн байдаг. Тэдгээр санал, санаачилга нь даруу төлөв, элэгсэг дотно, эв найртай байх Есүсийн сургаал номлолын нотолгоо болж байдаг бөгөөд тус сургаал номлол нь католик шашинтнуудын амьдрал хэмээх аялалдаа даган мөрдөж, дэлхийн бусад ард түмэнтэй зэрэгцэн алхах зам мөр болдог билээ. Эртний сурвалжит оюун санааны уламжлалыг хадгалсан, дэлхийн бараг бүх улс оронд байдаг католик сүм хийдийн институт шинжлэх ухаан, утга зохиол, урлаг, улс төр нийгмийн амьдралын олон чиглэлээр олон улс үндэстний хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулсаар байна” хэмээжээ. Католикчууд орчин үеийн нийгэмд (хүн ам, иргэн) шашны үйлс, номлол сургаал дан ганцаар хүний хэрэгцээг хангах боломжгүй гэж үзэн нийгэм, соёл, боловсролын салбарын үйл хэрэгтэй маш сайн уяж, уялдуулан ажиллах болжээ.

Түүхэн талаасаа Христийн шашны анхны том хагарал 1054 онд гарч албан ёсны сүм хийд нь католик ба үнэн алдрын ёсны болж хуваагдсан байдаг. Үүнд улс төр, эдийн засаг, оюун санааны олон хүчин зүйл нөлөөлсөн боловч юуны өмнө Ромын эзэнт гүрний задрал гол түлхэц үзүүлсэн байдаг. (А.С.Токарев, 1986, хууд. 509) Хэдий тийм боловч энэ хоёр чиглэлийн аль аль нь “Сүсэг бишрэлийн бэлгэ тэмдэг” хэмээх Есүс Христийн 12 элчийн тухай Христ шашинтны сүсэг бишрэлийн илэрхийлэл болсон гол үзэл номлолыг хүлээн зөвшөөрдөг. Уг номлолыг тунхагласан баримт бичгийг 325 оны Никейн нийт Христ шашинтны их чуулган дээр баталсан ба хожим 381 онд Константинополийн их чуулган дээр баталгаажуулсан ажээ. (А.Н.Мишкин, 1948, хууд. 553) Задралаас хойш Католик шашны дээрх үзэл номлолд зарим нэг өөрчлөлт, тодотгол орсон, 589 оны Толедагийн чуулган дээр оруулсан өөрчлөлт хагарлыг бүр гүнзгийрүүлсэн шалтгаан болжээ. (Е.А.Кулаков, 1996, хууд. 198) Толедагийн зөвлөл шүүгчид болон татварын ажилтнуудыг орон нутгийн шашны зөвлөлд ирж хүн амыг хэрхэн шударгаар шүүж, татвар ногдуулах талаар зааварчилгаа авахыг тушааснаар санваартнуудын захиргааны

чиг үүргийг өргөжүүлсэн. Өөрөөр хэлбэл, шашны захиргаа (теократ засаглал) иргэний засаг, захиргааг хянах, удирдах чиг үүрэгтэй гэж үзжээ. Католик шашны номлол нь сүмийг авралын зайлшгүй хэрэгсэл гэж тунхагладаг, учир нь зөвхөн сүм л хүний нүглийг арилгаж хамгийн гэгээн зорилгод хүрэхийн тулд хүмүүсийн тэнгэрлэг мөн чанарыг Бурхан(God)-аар дамжуулж сэргээж чадна. Мөн Бурханд зориулахаар шийдсэн онгон охид, бэлэвсэн эмэгтэйчүүдийн ариун байдлыг хадгалах тусгай хууль гаргасан нь цаанаа католик шашны санваартнуудын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг испани-ромчуудын нөлөөллийг бэхжүүлэх явдал байв. Эдгээр өөрчлөлтийг Зүүн Ромын сүм хийд хүлээн зөвшөөрсөнгүй. Энэ үйл явдлаас хойш баруун Ромын сүм хийд хэд хэдэн өөрчлөлт, тодотгол оруулсан ба эдгээр нь үнэн алдартны ёсноос ялгарах бас нэг онцлог нь болдог.

Католик шашны тэргүүн Ромын их хамба Папыг хамбуудын (кардиналуудын) зөвлөлийн тусгай хуралдаанаас нууц санал хураалтаар насан турш сонгодог ба тэрээр Ватикан (Гэгээн Ширээт улс) хот улсын тэргүүний албыг нэгэн зэрэг хашдаг. Пап лам нь дэлхий даяар орших бүх католик сүм хийд, байгууллагуудыг нэгтгэн удирдаж байна. Одоо дэлхийн 69 орны 203 кардинал байна. Тэд улаан нөмрөгөөрөө католик шашны бусад санваартнуудаас ялгардаг. Католик шашны бүх санваартнуудын хувьд заавал мөрдөх сахил нь гэрлэх ёсгүй байдаг. Ромын хамба лам буюу Петр гэгээнтний залгамжлагч болох Пап лам нь Шашны нэгдлийн суурь бөгөөд түүний үүрд үзэгдэхүйн үндэс болно. Тэрээр Христийн төлөөлөгч, хамба лам нарын бүлгийн тэргүүн, бүх нийтийн Шашны хариуцлагатан (хоньчин) бөгөөд тэнгэрлэг тогтоолоор Шашин дотор төгс, дээд, шууд, нийтлэг эрх мэдэлтэй байдаг.

Хамба лам нар бол элч нар дээр суурилсан итгэл бишрэлийн жинхэнэ гэрч болох ба Христийн эрх мэдлийг хэрэгжүүлэгчид учраас Пап ламтай нэгдэж, Сайн Мэдээг бүх хүнд найдвартай бөгөөд эрх мэдэлтэйгээр тунхаглах үүрэгтэй. Итгэл бишрэлийн ер бусын мэдрэмжээр Бурханы ард түмэн нь Шашны сургаал номлолын амьд эрх мэдлийн удирдлагын дор энэхүү итгэл бишрэлийг эндэлгүйгээр баримталдаг.

Католик шашин нь хамба буюу пап лам, хамба лам нар (бишопууд), лам санваартнууд, тахилч нар нөгөө талаас итгэгч нарын зохион байгуулагдсан цул нэгдэл юм. Католик шашин бол эрх мэдлийн хатуу шатлалтай байх зарчмын дагуу байгуулагдсан нийгмийн онцгой институт юм. Энэ нь сахил санваартны гурван үе шатлал бүхий түвшинд (хамба лам, лам санваартан, тахилч) суурилдаг; зохион байгуулалтын доод түвшинг дэд туслах, сүмээс зөвшөөрөн байгуулагдсан бусад байгууллагууд бүрдүүлдэг.

Католик шашны тэргүүн нь Пап лам, түүнийг сонгосон кардиналууд, мөн сүмийн санхүү, аж ахуй хариуцагчид, Ватикан ба Ромын Кури мужийг удирдан чиглүүлэхэд туслах үүрэгтэй кардиналуудын колледж⁴⁵ гэсэн шаталсан бүтэцтэй.

Оросын судлаач С.А.Токарев католик ба үнэн алдартны шашны ялгааг дараах байдлаар тодорхойлжээ. (А.С.Токарев, 1986, хууд. 509) Үүнд: Эцэг, Хүү, Ариун сүнсний ойлголтыг тайлбарлахдаа Католик шашинд Ариун сүнс бол Эцэг, Хүү аль алианаас нь үүддэг гэж үздэг. Гэтэл үнэн алдартны шашинд Ариун сүнс бол цор ганц Эцэгээс үүдэлтэй хэмээн үздэг. Энэ бол уг хоёр шашны хэзээ ч эвлэршгүй хамгийн том ялгаа болж байдаг. Мөн Католик сүм хийд нь Христ, түүний эх ба гэгээнтнүүд Бурханы өмнө өөрт нь оногдсон үүргээ төгс үйлдсэн учир тэр нь сүм хийдийн “эрдэнэсийн сан” болж хуримтлагдаж байдаг. Тэр сангаасаа Пап ламын нэрийн

⁴⁵ Ромын хамба лам буюу Папын шашны хариуцлагатны үйл ажиллагааг дэмжих зэмсэг гэсэн утгаар кардиналуудын коллегийн (нийт бүрэлдэхүүний) нэгдлийг бэлгэдэхийн тулд Кардинал болж буй хүнд Ром дахь шашны хүрээнд хамаарах сүмүүдээс эсвэл Ромын ойролцоох шашны хүрэнүүдээс аль нэгийг нь сонгон оноодог бөгөөд тухайн оноосон газрын нэр нь түүний цол гүншин болдог.

өмнөөс индульгенц⁴⁶ худалдах практик дундад зуунд дэлгэрсэн. Дээрх практиктай холбоотой ариусах орны тухай номлол Католик шашинд бий болжээ.

Христэд итгэгчид “тэнгэрийн орон, арилгах орон, там оршин байдаг болохыг нийтлэг хүлээн зөвшөөрдөг. Католик шашны ариусах орны тухай номлолыг анх 1439 оны Флоренцийн их чуулган дээр албан ёсоор баталсан ба 1562 онд дахин баталгаажуулсан байна. 1854 онд “Мариагийн язгуурын гэм нүгэлгүй бүрэлдсэн” тухай Ягшмал суртал батлагдаж, 1950 онд “Төгс жаргалант цэвэр охин Мариа тэнгэрт залагдсан” хэмээн зарлажээ. 1870 онд Ватиканы анхны чуулганаас сүсэг бишрэл, ёс суртахууны хэрэгт “Пап ламын эс эндэл” –ийг (нүгэлгүй байх) тунхаглажээ. Католик шашны ариуслын орны номлол ёсоор нүгэл хийсэн хүмүүсийн сүнс хүлээгээд ариусах ба хожим тэнгэрийн оронд очно хэмээн үздэг. Ариуслын орон нь нас барагсдын сүнс нь хувь тавиланг шийдэн бүр мөсөн арилах хүртэл оршдог завсрын орон зай юм. Ариуслын оронд сүнсний байх цаг хугацааг нас барагчийн ах дүү, хамаатан садан сүм хийдэд залбирах, ном уншуулах, өглөг өгөх замаар багасгаж болно гэж үздэг.

Тэнгэр, тэнгэрийн орон гэдэг нь дээд, төгс аз жаргалант байдлыг илтгэнэ. Бурханы хишиг ивээлт байдлын дотор нас барж, цаашид ариусгагдах шаардлагагүй хүмүүс нь Есүс, Мариа, тэнгэр элч нар, гэгээнтнүүдийг тойрон хүрээлдэг. Тэд тийнхүү тэнгэрийн Чуулганыг бүрдүүлж, Бурханыг “нүүр тулан” (1 Коринт 13:12) хардаг. Тэд Дээд Ариун Гурвалтай энэрэл хайрын нэгдэлд амьдардаг бөгөөд бидний төлөө зуучлан залбирдаг.

Арилгах орон гэдэг нь мөнхийн авралыг баттай олсон боловч тэнгэрийн орны аз жаргалыг хүртэхийн тулд ариусгагдах шаардлагатай байгаа Бурханы нөхөрлөлийн дотор нас барсан хүмүүсийн байдал юм.

Гэгээнтнүүдийн нэгдлийн тусламж дэмжлэгтэйгээр газар дэлхийд түр оршин сууж буй сүсэгтнүүд нь залбирлаар, ялангуяа Эвхаристын золиосоор дамжуулан арилгах оронд буй сүнснүүдэд тусалж болдог. Мөн өглөг, өршөөл, гэмшлийн үйлсээрээ тэдэнд туслах боломжтой.

Там бол өөрсдийн чөлөөт сонголтоор мөхлийн гэм нүгэлд автаж, нас барсан хүмүүсийн мөнхийн ял юм. Биднийг анх бүтээсэн зорилго ба бидний байнгын хүсэл тэмүүлэл болох амьдрал ба аз жаргал нь зөвхөн Бурханд л оршдог. Тиймээс тамын гол зовлон шаналал нь Бурханаас үүрд салан тусгаарлагдах явдал юм. Христ тэрхүү бодит байдлыг дараах үгсээр илэрхийлжээ: “Хараагдагсад аа, надаас зайлж, мөнх галд ор” (Матай 25:41).

“Төгс хүчит Бурханы гагц хишиг ивээл ба ариун нандин сонголт хийгээд хүн төрөлхтний Аврагч Есүс Христийн гавьяаны эрдэм буянаар Төгс Жаргалт Цэвэр Охин Мариа хэвлийд бүрэлдсэн анхныхаа мөчөөс язгуурын гэм нүглийн бүх толбоноос хамгаалагдсан.” гэдэгт Шашин итгэдэг (1854 оны Ягшмал суртал). Мариагийн язгуурын гэм нүгэлгүй бүрэлдсэн гэдэгт итгэх итгэл Шашны эхлэлээс оршин байсан.

Пап лам нь сэнтийнээсээ (латинаар ex cathedra) ягшмал сургаал номлолыг тогтоох үедээ л ер эндэлгүйгээр айлддаг. Өөрөөр хэлбэл, итгэл бишрэлийн болон ёс суртахууны сургаал номлолын асуултад эрх мэдэл бүхий шийдвэрийг гаргадаг байна. Үүнээс гадна Пап ламтай нэгдсэн хамба нарын бүлгэмийн номлол сургаалын тухай шийдвэрүүд нь эндэлгүй шинж чанар бүхий нэр хүндтэй байдаг. Пап ламын эс эндэл нь түүний ёс суртахууны бүрэн бүтэн байдал эсвэл түүний оюун ухаантай огт холбоогүй. Үнэний дотор Шашныг удирддаг, үнэн рүү улам гүн

⁴⁶ Индульгенци - (латин хэлний *indulgentia*, *indulgeo*-өршөөл, хайр хишиг) – Католик шашны сүм хийдийн орлогын нэг үүсвэр болох “өршөөл” худалдах практик дундад зуунд маш их хүчтэй болж олон түмний дургүйцлийг хүргэж байсан. Учир нүгэлтэн буюу гэм буруутан сүмд хандаж уг “өршөөл” үзүүлэх бичгийг худалдан авсанаар гэм зэмгүй нүгэлгүй хүн болдог. Католик сүм хийд нь, түүний эх гэгээнтнүүд ба Тэнгэрбурханы өмнө өөрт нь оногдсон үүргээ давуулан биелүүлсэн гавьяатай, тэр гавьяа нь сүм хийдийн мэдэлд байх “эрдэнэсийн сан” болж хуримтлагдаж байдаг гэж үзнэ. Энэ сангаасаа нүглийн “өршөөл” худалдах практик дундад зууны үед дэлгэрч нүглийн өршөөл болох “индульгенц”-ийг Пап ламын нэрийн өмнөөс олгодог байжээ.

хөтөлдөг өөрийн Ариун Сүнснийг Есүс амласан тул эс эндэл гэдэг нь чухамдаа Шашин юм. Олгогдсон итгэл бишрэлийн үнэнийг шууд үгүйсгэх эсвэл буруугаар тайлбарлах үед үнэн ба буруу гэж юу болохыг эрх мэдэлтэйгээр ярихын тулд Шашинд эцсийн нэг дуу хоолой байх ёстой бөгөөд энэ нь Пап ламын дуу хоолой юм. Петрийн залгамжлагч, хамба лам нарын дундаас анхдагч болохынхоо хувьд, тэр итгэл бишрэлийн Шашны Уламжлалын дагуу “баттайгаар итгэсэн байхын тулд” юмсыг бүх цаг үед сүсэгтнүүдэд санал болгодог иймэрхүү арга замаар эргэлзээтэй үнэнийг томъёолох эрх мэдэлтэй байдаг. Пап лам ягшмал сургаал номлолыг тогтоодог гэж бид ярьдаг. Тиймээс иймэрхүү ягшмал сургаал номлолд ерөнхийдөө “шинэ” юм огт багтдаггүй. Ягшмал сургаал номлолыг Пап лам ховорхон тогтоодог ба сүүлчийн удаа 1950 онд гаргажээ.

Авралын үйлд зайлшгүй зуучлагч болох сүмийн үүрэг нь ариун ёслол үйлдэх сургаалаар зөвтгөгддөг бөгөөд гүйцэтгэх явцад бурханлаг нигүүлсэл нь итгэгчидэд ач ивээлээ хүртээдэг. Католик шашин нь үнэн алдартны шашны нэгэн адил долоон үндсэн ёслолыг зөвшөөрдөг (Ариун угаал, Бататгал, Эвхарист, Эвлэрэл ~ Наманчлал, Өвчтөний Түрхлэг, Сахил санваарын хэргэм, Гэрлэлт) бөгөөд тэдгээрийн ойлгох үйлдэхэд ялгаа гардаг. Католик шашинд загалмайлх ариун ёс нь Ариун угаал хүртсэн хүний толгой дээр ус асгах эсвэл усанд шумбуулах замаар үйлдэгддэг бол үнэн алдартны шашинд зөвхөн усанд дүрэх замаар хийдэг.

Христ тогтоож, шашинд даатгасан үндсэн ёслолуудаар уламжлан бидэнд тэнгэрлэг амьдралыг өгдөг. Ариун угаал, Бататгал, Ариун Эвхарист, Наманчлал, Өвчтөний Түрхлэг, Сахил Санваарын Хэргэм ба Гэрлэлт гэсэн үндсэн 7 ёслол байдаг ажээ.

Монгол дахь Католик шашинтнууд 2022 оны 07 сарын 10-ны өдөр 30 жилийн ойн баярын мөргөлийг нийт Католик шашны сүсэгтнүүдээс гадна хүндэт зочид төлөөлөгчдийн хамт тэмдэглэжээ. Монгол дахь Католик шашны анхны хамба ламаар Вэнсэслао Падилла ажиллаж байв. 2020 онд түүний залгамжлагчаар Улаанбаатар хот дахь Апостолик тэргүүн, Кардинал Жиоржио Маренгог Монгол дахь Католик шашны хамба ламаар томилсон байна. Улмаар 2022 онд Ром хотод Кардиналуудын уулзалтаар (Consistory) Пап Францис түүнийг Гэгээн Жиуда Таддео Апостоло хэмээх цол олгон Кардинал болгосон байна. Тэрбээр⁴⁷ “20 жилийн өмнө анх ирэхэд тал нутагт үйл ажиллагаа явуулах, мөргөл үйлдэх хоёр гэр босгосон байсан” гэж дурсаад XIX зууны сүүлчээр Монголд ирсэн Францын Католик шашны номлогч буддын шашны сүм хийдүүдийн уламжлалыг хараад “хэзээ нэг цагт энд католик шашны сүм хийдтэй болох ёстой” хэмээснийг дурсав. Монголчууд буддын шашин соёл, сүм хийд, лам нарын заримыг устгаж, үлдсэнийг нь шашны амьдралаас татгалзуулж, нэг намын үзэл сурталд хүчээр оруулж байсан түүхийг дурдахаа Пап мартсангүй. Кардинал Жиоржио Маренго “Гурван жил хөөцөлдсөний хүчинд газартай, сүмтэй болж” улмаар “монголын уудам оронд сайн мэдээг амжилттай түгээж 1450 орчим шашны итгэгчтэй” болж Монгол дахь Католик шашны нийгэмлэгийн үйл ажиллагааг өнгөрсөн хугацаанд амжилттай удирджээ.

Монгол Улсад Ромын Пап лам 2023 оны 08 сарын 31-нээс 09 сарын 04-нд албан ёсны айлчлал хийв. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх айлчлалыг нээж хэлсэн үгэндээ “Та бүхэнд мөнх хөх тэнгэрийн орон, дэлхийн мянганы суут хүмүүн Их эзэн Чингис хааны өлгий нутаг, Монголын эзэнт гүрний гал голомт манай сайхан эх оронд Гэгээн Ширээт Улсын төрийн тэргүүн Пап Францис анх удаа айлчлал хийж байгаа энэхүү түүхэн өдрийн мэндийг өргөн дэвшүүлье. Энэхүү түүхэн айлчлал нь Чингис хааны мэндэлсний 860 жил, Монгол Улс, Гэгээн Ширээт Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны түүхт 30 жилийн ойн хүрээнд болж байгаагаараа ач холбогдогтой юм” хэмээн онцлон тэмдэглэжээ. МУ-ын ерөнхийлөгч У.Хүрэлсүх

⁴⁷ Эх сурвалж. <https://www.ncregister.com/cna/cardinal-in-mongolia//> Католик шашны албан ёсны сайтад Кардинал Жиоржио Маренгогийн өгсөн ярилцлагын товч агуулгыг энд оруулав.

“Монголчууд эрт дээр үеэс оюун санааны эрх чөлөөг дээдэлж, олон ургальч үзлийг хүндэтгэж ирсэн түүхэн уламжлалтай бөгөөд эзэн Чингис хаан, Их Монгол Улсын үеэс монгол хаад, язгууртнууд аливаа шашин шүтлэгт хүндэтгэлтэй хандан, сүм хийдийг алба татвараас чөлөөлж, нийслэл Хархорум хотод Буддын, Христийн, Исламын зэрэг 12 сүм дуган зэрэгцэн оршиж байсан түүхтэй билээ. Оюун санаа, итгэл үнэмшлийн эрх чөлөөг хүндэтгэх энэхүү үзэл санааг өнөөгийн монголчууд залгамжлан хөгжүүлж Үндсэн хуульдаа тунхаглан дархалсан” болохыг Пап лам, түүнийг дагалдан явж буй зочид төлөөлөгчид, нийт ард иргэддээ хандан хэлсэн.

Гэгээн Ширээт Улсын тэргүүн “Энхийг эрхэмлэн эргэл мөргөлөөр замнан яваа санваартан миний бие Та бүхний хүмүүнлэг ёс, найрсаг зан аальд хөгжин, талархан баясах хүсэл тэмүүлэлдээ хөтлөгдөн, зүрх сэтгэлдээ аз жаргалыг тээж, амар амгаланг өвөрлөн ийнхүү өргөө гэрийн тань үүдэнд хүрэлцэн ирлээ. Бид анд нөхдийнхөө гэрт зочлон ирэхдээ мэндээ бэлгээ солилцож, эртний түүхээ эргэн дурсдаг сайхан уламжлалтай” хэмээгээд “Монгол дахь Католик шашны сүсэгтнүүд хэдий цөөхүүлээ боловч эв нэгдэл, шашин хоорондын яриа хэлэлцээ, харилцан хүндэтгэлийн соёлыг түгээж, нийгмийн шударга ёс, энх тайван, эв найрамдлын төлөө ажиллан, улс орны хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж байгаад баяртай” гэжээ. Ромын Пап “дэлхий нийтийн энх тайван, байгаль, экологийн тэнцвэрт байдал, улс орны хөгжлийн саад болсон авилга, хээл хахууль”-ийн тухай онцлон дурдаад монголчуудыг эртний сайхан уламжлалтай ард түмэн тул эдгээрийг зөв шийдвэрлэж, уламжлал, шинэчлэлийг зөв хослуульж хөгжихийг уриалжээ.

Монголд суугаа Кардинал Жоржио Маринго “Монголд Католик сүм байр сууриа баттай олсноор сайн мэдээг илүү үр дүнтэй түгээх болно. Сайн мэдээг түгээхдээ тухайн соёлын зүрхэнд хүртэл түгээхгүй бол өнгөц түрхсэн будаг шиг хагарч, бүдгэрч алга болно” гэжээ. Тэрээр сайн мэдээг түгээх Католик шашны зорилгыг нууж хаах ёсгүй хэмээснээс үзвэл Ромын Папын айлчлал Монголын нийгэм дэх Христ итгэлтнүүдийн байр суурь бэхжиж, христийн номлол сургаал түгэх шинэ эрин үеийг авч ирж байгаа, басхүү Монголд Католик шашин бэхэжвэл Ватиканы эрх мэдэлтнүүд манай орныг урд, хойд хөрш рүү сайн мэдээ түгээх таатай түшиц газар гэж үзэж байж болох⁴⁸ юм хэмээн дүгнэжээ. Мөн Монголын их эзэнт гүрний үед манай их хаад аливаа шашны төлөөлөгчдөд хөл алдаж сүйд болж байгаагүйг түүхийн эх сурвалжуудад тодорхой тэмдэглэгдсэн байдгийг судлаач С.Дэмбэрэл дурджээ. Олон Улс судлалын хүрээлэнгийн захирал, судлаач Д.Золбоо “Ромын Папын айлчлал бол Монгол Улс дэлхий дахинд шашин шүтлэг, хүний эрхийг дээдэлдэг улс орнуудын нэг гэдгээ бататгах том боломж” гэжээ⁴⁹.

Орчин үеийн шашны байгууллагуудын нэг түгээмэл онцлог нь зөвхөн сүм хийд, итгэгч нартаа үйлчлэл үзүүлэх үйл ажиллагаагаар хязгаарлагддаггүй байдал юм. Тэд соёл боловсрол, эдийн засаг, эрүүл мэнд, нийгэм-улс төрийн бүхий л салбаруудад янз бүрийн үйлчлэл үзүүлж, идэвхитэй үйл ажиллагаа явуулж байдаг онцлогтой. Монголд эдүгээ Улаанбаатар хотод “Гэгээн эх Мариа католик сүм”, “Сайн хоньчин католик сүм”, “Гэгээн софия католик сүм”, “Гэгээнтэн Томас Аквинагийн католик сүм”, “Ариун гэр бүл католик сүм” гэсэн нийт таван сүм хийд, Дархан-Уул аймагт “Сүсэгтнүүдийн туслагч эх Мариа католик сүм”, Төв аймагт “Энэрэнгүй Бурханы сүм”, Өвөрхангайд “Энэрлийн эх католик сүм”, Эрдэнэт хотод “Тэнгэрлэг нигүүлсэл католик сүм” нийт 9 сүм үйл ажиллагаа явуулж байна⁵⁰. Сүмийн тогтсон хөтөлбөрүүдийн зэрэгцээ нийгмийн үйлчилгээг төрөл бүрийн салбарт явуулдаг. Жишээ нь, Антон Мостаэрт Монгол судлалын төв, Сэйнт Мэри буяны эмнэлэг, бага сургууль, цэцэрлэг, сургалт үйлдвэрлэлийн төв, скаут гэх мэтчилэн маш олон салбарт үйл ажиллагаа явуулж байна.

⁴⁸ <https://www.facebook.com/demberels> // Судлаач С.Дэмбэрэлийн үнэлэлт, дүгнэлтийг энд авч оруулсан болно.

⁴⁹ <https://iis.ac.mn/c/1011670?content=3936738> Судлаач Д.Золбоогийн айлчлалын талаарх ярилцлагыг үзэж болно.

⁵⁰ Эх сурвалж. <http://www.catholicchurch-mongolia.mn/morgoliin-tsag>

Манай орны тухайд христийн уламжлал бүхий тэр дундаа Католик шашин нь өөрийн сүсэгтэнтэй, үйл ажиллагааны хөтөлбөртэй, үр өгөөж, амжилт бүтээлтэй монголын нийгмийн нэг хэсэг болж төлөвшжээ. Тэдний явуулж буй үйл ажиллагаанд эрх зүйн орчин, хуулийн зохицуулалттай холбоотой асуудал буйг цаашид анхаарах нь зүйтэй.

Ном зүй

1. А.Н.Мишкин. (1948). *История древнего Рима*. ОГИЗ: См. Об этом напр.
2. А.С.Токарев. (1986). *Религия в истории народов мира*. Москва: См. Об этом напр.
3. Е.А.Кулаков. (1996). *Религии мира*. Москва: См. Об напр.

Цахим эх сурвалжууд.

1. <https://www.ncregister.com/cna/cardinal-in-mongolia //>
2. <https://www.facebook.com/demberels //>
3. <https://iis.ac.mn/c/1011670?content=3936738>

Feature of Catholic Religion

Catholicism is one of the important foundations of European culture. As a result of the democratic revolution of the 1990s in our country, Catholicism has spread in Mongolia. Catholicism and its teachings have become a part of Mongolian culture and operate in many areas of society.